МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр,
Утас: 31 06 12, 7600 3333-1126, Факс: (976-11) 32 29 04,
И-мэйл: info@mcud.gov.mn, Вэбсайт: www.mcud.gov.mn

2021·12·31 № 3/5515

танай ____________-ны №____________-т

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ

Тайлан хүргүүлэх тухай

Барилга, хот байгуулалтын яамны Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт болон Авлигын эсрэг үйл ажиллагааны үйл ажиллагааны жилийн эцсийн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ..35.. хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА С.МАГНАЙСҮРЭН

151059747

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ БОЛОН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2021 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН**

**2021.12.25**

**Нэг. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:**

| № | Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа | Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжилт | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллагын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| **Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөлөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр** | | | | | | |
| 1 | 4.1.1.1. төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх | Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСХУМ/-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох | Нэг.Барилга, хот байгуулалтын яаманд ажиллаж буй нийт 62 албан хаагчийн 2020 оны Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулж, нэгтгэн, тайланг Авлигатай тэмцэх газарт 2021 оны 3/645 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн тус яаманд шинээр ажилд орсон 32 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу урьдчилсэн мэдүүлгийг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт тухай бүр хүргүүлж ажилласан.<br><br>1. Салбар зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар байгуулсан ажлын | 100 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хэсэг, Төрийн албаны зөвлөлтэй хамтран 8 албан тушаалын сул орон тоог нөхөхөөр сонгон шалгаруулатыг зохион байгуулж 14 хүний бүртгүүлснээс 7 албан тушаалтныг томилох талаар нэр дэвшүүлэн томилох эрх бүхий албан тушаалтанд мэдэгдлийг хүргэж ажилласан. Үүнд:<br>1.Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн нэгдсэн төлөвлөлт хариуцсан ахлах шинжээчийн албан тушаалд Нямжавын Хуланг;<br>2.Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Барилга, байгууламжийн үйлдвэрлэлийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах шинжээчийн албан тушаалд Гансүхийн Эрхэмбаярыг;<br>3.Барилга байгууламжийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, өргөх байгууламжийн бодлого, зохицуулалт хариуцсан шинжээчийн албан тушаалд Эрдэнэбилэгийн Золзаяаг;<br>4.Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хүн амын нутагшилт, суурьшил бүс нутгийн хөгжлийн бодлого, зохицуулалт хариуцсан шинжээчийн албан тушаалд Самдангийн Дэнсмааг;<br>5.Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Орон сууцны ашиглалт, үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд Пүрэв-Ойдовын Очирдавааг;<br>6.Инженерийн дэд бүтцийн хэлтсийн Цахилгаан хангамж, автоматик, холбоо-дохиоллын бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд Баярсайханы Энхчимэгийг;<br>7.Бодлого, төлөвлөлтийн газрын Орон сууц, санхүүжилтийн хэлтсийн Ипотек, түрээсийн тогтолцоо хариуцсан ахлах мэргэжилтний албан | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тушаалд Даваажаргалын Алтангэрэл нарыг санал болгосон тогтоол гарган томилууллаа.<br>Хоёр.Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 05 дугаар тогтоолоор тус яамны 4, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 11 сул орон тоог нөхөх тусгай шалгалт зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж 35 хүн бүртгүүлсэнээс 15 албан тушаалтныг томилох талаар нэр дэвшүүлэн томилох эрх бүхий албан тушаалтанд мэдэгдлийг хүргэж ажилласан. Үүнд Хамгийн өндөр оноо авч нэр дэвшсэн:<br>Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн Хот байгуулалт, газрын харилцааны салбарын эрх зүйн зохицуулалт хариуцсан ахлах шинжээчийн албан тушаалд Ц.Батчимэг, Бодлого, төлөвлөлтийн газрын Орон сууц, санхүүжилтийн хэлтсийн Орон сууц төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан шинжээчийн албан тушаалд Д.Алтангэрэл, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Салбарын үйл ажиллагааны аудит хариуцсан шинжээчийн албан тушаалд Г.Мөнх-Эрдэнэ, Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Барилгын материалын чанар, аюулгүй байдлын бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн албан тушаалд Б.Хосбаяр, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Суурь судалгаа, мониторингийн хэлтсийн даргын албан тушаалд Б.Дөл, Хот байгуулалтын кадастрын хэлтсийн даргын албан тушаалд Х.Оюунбаяр, Орон зайн мэдээлэл, технологийн хэлтсийн даргын албан тушаалд П.Нямдаваа, Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газрын Салбарын эрхзүйн зохицуулалт, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн албан тушаалд Ц.Цогтжаргал, | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Орон зайн мэдээлэл, технологийн хэлтсийн Орон зайн өгөгдлийн сангийн удирдлагын систем, технологийн шийдэл хариуцсан ахлах мэргэжилтэн албан тушаалд Д.Баянбаатар, Кадастрын хэлтсийн Газрын үнэлгээний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн албан тушаалд А.Энхбаатар, Хот байгуулалтын хэлтсийн Хот байгуулалтын норм, дүрмийн хэрэгжилт, тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн албан тушаалд А.Энхнаран, Кадастрын хэлтсийн Газрын кадастрын мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн албан тушаалд Э.Алтан-Эрдэнэ, Газар зохион байгуулалтын хэлтсийн Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн албан тушаалд Ж.Ганзориг, Суурь судалгаа, мониторингийн хэлтсийн Ой, усны сан бүхий газрын мониторинг, нөхөн сэргээлт хариуцсан мэргэжилтэн албан тушаалд М.Ууганзаяа, Хот байгуулалтын хэлтсийн Дэд бүтцийн төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Б.Алтаншагай нарыг тус тус томилсон.<br>3. Салбар зөвлөлийн 2021 оны 07 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг агентлагын 4 сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтад 8 хүн бүртгүүлсэнээс 1 нь шалгалтад ирээгүй 7 хүнийг оролцуулж 3 албан хаагчийг нэр дэвшүүлэн санал болгож эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.<br>Төрийн албаны тусгай шалгалтын сонгон шалгаруулалтаар хамгийн өндөр оноо авсан Кадастрын хэлтсийн Газрын татвар, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Э.Энх-Эрдэнэ, Орон зайн мэдээлэл, технологийн хэлтсийн Орон зайн өгөгдлийн сангийн менежмент хариуцсан мэргэжилтний албан тушаалд Г.Хулан, Газар зохион | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулалтын хэлтсийн Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтний албан тушаалд Г.Пүрэвжаргал нарыг салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд томилуулах саналаа эрх бүхий этгээдэд хүргүүлж, улмаар уг албан тушаалд томилогдохоор нэр дэвшиж байгаа этгээд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3, 22.1.5-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэх тухай баримтыг холбогдох байгууллагуудаас авч тус бүрийн хувийн хэрэгт хавсаргахыг анхааруулж, биелэлтэд нь хяналт тавьж ажилласан.<br>Яаманд шинээр томилогдсон албан хаагчдад албан тушаалын тодорхойлолтыг танилцуулж, гарын үсэг зуруулахын зэрэгцээ хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах, ял шийтгэлгүйн тодорхойлолт ирүүлэх, гүйцэтгэлийн төвөвлөгөө боловсруулах, зарим албан хаагчдын ажлыг хүлээлцэх зэрэг хугацаатай мэдэгдлийг хүргүүлж ажилласан.<br>Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСХУМ/-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод нээлттэй болгож, Барилга, хот байгуулалтын яамны https://mcud.gov.mn/a/622 цахим хаягийн ил тод /Авлигын эсрэг/Урьдчилсан мэдүүлэг хянасан гэсэн талбарт байршуулж хэвшсэн.<br>Мөн 2021 онд сүүлийн хагас жилд шинээр томилогдсон 11 албан хаагчдын ХАСХУМ-ыг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | нийт 62 албан хаагчийн ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд бүрэн гаргаж хянан баталгаажуулсан. | | | |
| | | Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох | Хүний нөөцийн программд байгууллагын албан хаагчдын хөдөлгөөн, цалин, хоол, унаа, зэрэг дэв болон холбогдох бусад нэмэгдлүүдийг бүрэн бүртгэж оруулсан.<br><br>Хүний нөөцийн ил тод байдалтай холбоотой мэдээллийг яамны цахим хуудас https://mcud.gov.mn/as/tasz-д болон шилэн дансны htts://shilendans.gov.mn/ системд байршуулахаас гадна Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу олон нийтэд мэдээлж, сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг 7 хоногт сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн ажиллаж байна. Мөн ажлын байрны зарыг нээлттэй https://mcud.gov.mn/as/ajliinzar цахим сайтад тухай бүр байршуулж байгаа болно. | 100 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | 4.1.1.2. нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтны мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмын баримтлан томилох дэвшүүлэх | Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх | 2021 оны жилийн эцсийн байдлаар орон тооны нөхөн хангалт 62 албан хаагч 100 хувьтайгаар зохион байгуулалтын үйл ажиллагаагаа явуулж байна.<br>"Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалинг 8 хувь, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 75 дугаар тогтоолоор яамны албан хаагчдын цалинг 42 хувиар нэмэгдүүлсний дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн Б/05, 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Б/30-р тушаалаар албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоосон.<br>Үүнтэй холбогдуулан шинээр ажилд орж байгаа болон шатлан дэвшсэн албан хаагчдын цалинг тухай бүр тооцож олгож байгаа болно.<br>Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн шийдвэрээр Барилга, хот байгуулалтын яамны сайдын Б/92, Б/240 дугаар Төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай тушаалаар яам болон агентлагын 31 албан хаагчдын зэрэг дэвийг нэмэгдүүлсэн. Үүнд:<br>Ахлах түшмэлийн тэргүүн зэрэг-2 албан хаагч;<br>Ахлах түшмэлийн дэд зэрэг-4 албан хаагч;<br>Ахлах түшмэлийн гутгаар зэрэг-2 албан хаагч;<br>Ахлах түшмэлийн дөтгөөр зэрэг-7;<br>Дэс түшмэлийн гутгаар зэрэг-3 албан хаагч;<br>Дэс түшмэлийн дөтгөөр зэрэг -4 албан хаагч байна.<br>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас<br>Дэс түшмэл тэргүүн зэрэг-1 албан хаагч<br>Дэс түшмэл гутгаар зэрэг-2 албан хаагч | 100 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Дэс түшмэлийн дэтгээр зэрэг-4 албан хаагчид тус тус зэрэг дэвийн нэмэгдлийг олгуулсан.<br>Төрийн нарийн бичгийн даргын Б/54, Б/126 тушаалаар яамны 9 албан хаагчийн төрд ажилласан жилийн нэмэгдлийг шийдвэрлэсэн.<br>Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 05 дугаар 24-ний өдрийн Б/71 Албан хаагчдын 2021 оны ээлжийн амралтын хуваарь батлах тухай тушаалаар ээлжийн амралт олгох шаардлага хангасан албан хаагчдын хувиарыг батлуулж хэрэгжилт хангагдсан.<br>Засгийн газрын 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үр дүнг үндэслэн Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн Б/55 дугаар тушаалаар 41 албан хаагчийн цалингийн шатлалд өөрчлөлт оруулан шинэчлэв.<br>ТАЗ, Удирдлагын академаас зохион байгуулсан Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх чиглэлээр эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 3, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 6, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад 9, төрийн албанд шинээр богино болон дунд хугацааны давтан сургалтанд 11 нийт 29 албан хаагчийг сургалтад хамруулав. Мөн Удирдлагын академаас зохион байгуулсан Алсын хараа-2050 Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ сэдэвт богино хугацааны сургалтад 16 албан хаагчийг зайн буюу онлайн хэлбэрээр хамруулав. Төрийн албаны зөвлөлөөс Пүрэв гариг бүр зохион байгуулсан 21 удаагийн вебинарт яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | давхардсан тоогоор 106 албан хаагчийг хамруулж яам болон харьяа байгууллагын цахим хуудсанд нийтэлж, нийслэл, аймаг, орон нутгийн нийт төрийн албан хаагч, олон нийтэд түгээн сурталчилж ажилласан. | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | 4.1.1.9. төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл боломжийг сайжруулах | Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцэд холбогдох | E-Mongolia үндэсний цахим үйлчилгээний нэгдсэн системийг бий болгох төслийн нэг бүрэлдэхүүн хэсэг болох төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн систем www.erp.e-mongolia.mn -ыг танилцуулах үйл ажиллагааг 2021 оны 1 дүгээр сард Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай хамтран зохион байгуулсан ба уг үйл ажиллагаанд БХБЯ, ГЗБГЗЗГ, БХТ, ТОСК, ХСУХАТАҮЗЗ-ийн холбогдох албан тушаалтнууд оролцсон. БХБЯ, ГЗБГЗЗГ, БХТ, ТОСК, ХСУХАТАҮЗЗ-ын холбогдох мэдээллүүдийг нэгтгэн ХХМТГ-т хүргүүлж, www.erp.e-mongolia.mn -ийн нэвтрэх эрхүүдийг үүсгэсэн. Одоогийн байдлаар ТОСК-ийн 35 албан хаагч, ХСУХАТАҮЗЗ-ийн 22 албан хаагч бүртгэгдэж, үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлээд байна. Уг системийн цахим сургалтыг 2021.01.21-ны өдөр зохион байгуулж, харьяа байгууллагуудын хүний нөөц, бичиг хэрэг, мэдээллийн технологийн асуудал хариуцсан албан тушаалтнуудыг бүрэн хамруулсан. Сургалтын үр дүн албан бичиг хэрэг хөтлөлтийн модулийг сайжруулах ажлын хэсгийг ХХМТГ байгуулж, тус яам болон харьяа байгууллагуудын бичиг хэргийн асуудал хариуцсан албан тушаалтнууд хамрагдсан. https://erp.e-mongolia.mn системд яамны бүтцийн нэгжийн орон тоо, чиг үүрэг, албан тушаал, албан тушаалын чиг үүрэг, хүний нөөцийн мэдээллийг бүртгэн оруулж, 2021.06.30-ний өдөр нийт албан хаагчдад зориулсан сургалтыг зохион байгуулж, 2021.07.01-ний өдрөөс эхлэн яамны дотоод үйл ажиллагаанд нэвтрүүлж, албан хаагчдыг арга зүйгээр ханган ажиллаж байна. Албан хэрэг хөтлөлтийн модулийг сайжруулах чиглэлээр Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газартай хамтран ажиллаж, холбогдох сайжруулалтуудыг хийсэн. | 100 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | “Төрийн байгууллагын албан бичиг солилцооны цахим систем docx.gov.mn”-тэй холбох ажлыг зохион байгуулж, 2021.11.30-ний өдрөөс эхлэн холбогдож, бүх төрийн байгууллагуудтай албан бичиг солилцох бүрэн боломжтой болсон. ERP дотоод удирдлагын систем нь нийтийн түлхүүрийн дэд бүтцийн системд бүрэн холбогдсон бөгөөд уг системд холбогдсон байгууллагуудтай тоон гарын үсэг ашиглан цахим албан бичиг солилцох боломж бүрдсэн. | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ, сан байгуулах | Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор барилгын салбарын цахим шилжилтийн арга хэмжээний төлөвлөгөөг БХБ-ын сайдаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Уг төлөвлөгөө нь БХБЯ түүний харьяа 4 байгууллагын 19 зорилтын 71 арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар 100 хувийн гүйцэтгэлтэй<br>-Газрын харилцааны салбарын тусгай зөвшөөрлийн болон мэргэжлийн байгууллагын эрх олгох цахим үйлчилгээ /license.mcis.gov.mn/;<br>-Газрын кадастрын цахим систем /egazar.gov.mn/;<br><br>-Газрын харилцааны салбарын тусгай зөвшөөрлийн болон мэргэжлийн байгууллагын эрхтэй холбоотой лавлагаа, тодорхойлолт /license.mcis.gov.mn/;<br><br>-Газрын харилцааны салбарын төрийн болон байгууллагын архивын баримтын цахимжуулалт;<br><br>-Геодези, зураг зүйн бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимжуулах, цахим үйлчилгээ /geocalc.gazar.gov.mn, monpos.gazar.gov.mn, point.gazar.gov.mn/;<br><br>-Газрын кадастрын мэдээллийн лавлагаа /egazar.gov.mn, E-GAZAR мобайл апп/;<br><br>-Барилгын салбарын нэгдсэн мэдээллийн сангийн цахим систем /www.mcis.gov.mn/;<br>-Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн цахим систем /license.mcis.gov.mn/; | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | -Ундны усны чанарын нэгдсэн мэдээллийн сан /water.wsrc.mn/;<br>Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” цонхонд дараах 5 үйлчилгээ холбогдоод байна. Үүнд:<br>1.Газрын кадастрын нэгж талбарын тодорхойлолт;<br>2.Газар эзэмших эрхийн лавлагаа;<br>3.Үнэгүй газар өмчилсөн эсэх лавлагаа;<br>4.Газрын төлбөрийн тооцоо нийлсэн лавлагаа;<br>5.Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн шүүхийн шийдвэртэй эсэх лавлагаа;<br>Мөн Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” цонхонд дараах 5 үйлчилгээний холбоосыг оруулсан байна. Үүнд:<br>1.Геодезийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авах;<br>2.Геодезийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл сунгах;<br>3.Геодезийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл сэргээх;<br>4.Геодезийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл нөхөж авах;<br>5.Геодезийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тодорхойлолт.<br>Дэлхийн банкны Ухаалаг засаг төслийн хүрээнд “Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал (www.opendata.gov.mn)”-ыг ашиглалтад оруулсан. Төрийн байгууллага өөрийн эзэмшиж буй өгөгдлөө иргэдэд нээлттэйгээр ашиглуулах, эдийн засгийн эргэлтэд оруулж, баялаг бий болгох зорилготой тус порталд барилгын салбар нээлттэй өгөгдөл, мэдээллийг байршуулж, өгөгдөл, мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.<br>“Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал (www.opendata.gov.mn)”-д барилга, газар, орон зайн өгөгдөл гэсэн 3 бүлгийг үүсгэн нээлттэй | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | өгөгдөл, мэдээллийг тогтмол байршуулж байна. Барилга, газар бүлгүүдэд салбарын судалгаа, статистикийн тоон мэдээллүүд, орон зайн өгөгдөл бүлэгт газрын гадарга дээрх, доорх ус, агаар, сансрын орон зайд орших байгалийн болон хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, үзэгдлийн байршил, хэмжээ, шинж чанарыг тодорхойлж буй 60 өгөгдөл, мэдээллийг байршуулаад байна.<br>Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 206, А/184 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Салбарын бүртгэл, мэдээллийн маягт, нөхөх заавар"-ын дагуу барилгын ажил гүйцэтгэх, зураг төсөл боловсруулах, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт засвар үйлчилгээ эрхлэх, инженер геологийн судалгааны ажил гүйцэтгэх, нийтийн аж ахуйн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааны 2020 оны жилийн тайлан, мэдээг бэлтгэн Үндэсний статистикийн хороонд 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 3/774 албан бичгээр, 2021 оны хагас жилийн тайлан, мэдээг нэгтгэн Үндэсний статистикийн хороонд 2021.07.28-ны өдрийн 3/3040 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.<br>Орон сууцны албан ёсны статистикийн мэдээний "Ашиглалтад орсон нийтийн зориулалттай болон амины орон сууцны байшингийн 20... оны бүтэн жилийн мэдээ"-ний маягтын дагуу 2020 оны жилийн тайлан, мэдээг бэлтгэн Үндэсний статистикийн хороонд 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 5/401 албан бичгээр, 2021 оны хагас жилийн тайлан, мэдээг батлагдсан маягтын дагуу гарган Үндэсний статистикийн хороонд 2021.07.28-ны өдрийн 3/3041 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | 4.1.1.10. нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх | Албан хаагчдыг төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалтад хамруулах | Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академаас зохион байгуулсан Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх чиглэлээр эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 3, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 6, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад 9, төрийн албанд шинээр богино болон дунд хугацааны давтан сургалтанд 11 нийт 29 албан хаагчийг сургалтад хамруулав.<br>Мөн Удирдлагын академаас зохион байгуулсан Алсын хараа-2050 Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ сэдэвт богино хугацааны сургалтад 16 албан хаагчийг зайн буюу онлайн хэлбэрээр хамруулав.<br><br>Төрийн албаны зөвлөлөөс Пүрэв гариг бүр зохион байгуулсан 21 удаагийн вебинарт яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас давхардсан тоогоор 106 албан хаагчийг хамруулж яам болон харьяа байгууллагын цахим хуудсанд нийтэлж, нийслэл, аймаг, орон нутгийн нийт төрийн албан хаагч, олон нийтэд түгээн сурталчилж ажилласан. | 100 | | |
| | | Албан хаагчдыг авлигын эсрэг төлөвлөгөөт сургалтад хамруулах | Тайлант хугацаанд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах хадгалах журмыг хэрэгжүүлэн ажиллаж ямар нэгэн зөрчил дутагдал гаргаагүй бөгөөд сургалт мэдээллийг 2 удаа зохион байгуулсан болно.<br>Авлигын эсрэг хуульд мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж | 100 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж өгөх үүрэгтэй гэж заасны дагуу яамны дотоод цахим системд /ttps://mcud.able.mn/main.php?p=cHiVbGlj/ мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага болон яамны Эрх бүхий албан тушаалтны боловсруулсан ЗӨВЛӨМЖИЙГ 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр байршуулсан.<br>Мөн 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр шинээр төрийн албанд орсон /хуульд заасан үндэслэлээр түр орлон гүйцэтгэж байгаа зэрэг/ 5 албан хаагчдад ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хөрөнгө орлогын мэдүүлгийг хэрхэн гаргах талаарх сургалтыг биечлэн зохион байгуулсан.<br>Авлигатай тэмцэх газраас 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 11:00 цагаас цахимаар /zoom/ зохион байгуулсан авлигын эсрэг үндэсний сүлжээний системийн талаарх сургалтад байгууллагын албан хаагчдыг бүрэн хамруулсан бөгөөд коронавирусийн цаг үеийн байдлаас шалтгаалан цахим хэлбэрээр сургалтыг зохион байгуулж ажилласан.<br>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан Хуулийн асуудал хариуцсан албан тушаалтнуудад зориулсан Авлигын эсрэг давтан сургалтын Авлигатай тэмцэх газраас 2021 оны 11 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд танхимын хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд тус сургалтад Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлстийн ахлах шинжээч Ц.Батчимэг хамрагдсан.<br>Нэгдсэн Үндэсний Байгууллагаас зарласан Авлигын эсрэг олон улсын өдрийг дэлхий нийтээр “Таны эрх-Таны оролцоо; Авлигад үгүй гэж хэлье” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж байгаатай холбогдуулан Авлигатай тэмцэх газраас “Авлигын эсрэг үндэсний чуулган | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2021” арга хэмжээг 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан бөгөөд уг чуулганд Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж, мөн тус хэлтсийн шинжээч Б.Мягмардорж нар тус тус амжилттай оролцсон. | | | |
| **Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр** | | | | | | |
| 1 | 4.1.2.1. төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх | Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга | “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор доорх үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлээд байна. Үүнд:<br>Геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох (http://license.gazar.gov.mn );<br>Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох (http://license.gazar.gov.mn );<br>Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох (http://license.mcis.gov.mn );<br>“Барилгын материал үйлдвэрлэгч аж ахуй нэгжид тусгай зөвшөөрөл олгох“ (http://license.mcis.gov.mn );<br>Зураг төслийн баримт бичигт магадлал хийх үйлчилгээ (barilga.gov.mn).<br>Барилгын салбарын нэгдсэн мэдээллийн сангийн цахим системийг хөгжүүлэх ажлын хүрээнд дараах системүүд цахим хэлбэрт шилжээд байна. Үүнд: | 100 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Норм, нормативийн мэдээллийн сангийн систем - www.msic.gov.mn;<br>Сургалт, судалгааны систем http://barilga.gov.mn/ ;<br>Захиалагчийн хяналтын удирдлын систем http://barilga.gov.mn/ ;<br>Хууль, эрх зүйн нэгдсэн мэдээллийн сан www.msic.gov.mn;<br>Салбарын тусгай зөвшөөрлийн цахим системийг Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем, Танилт нэвтрэлтийн ДАН системүүдтэй холбогдож, Боловсрол, шинжлэх ухааны яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газруудаас мэдээлэл авч солилцон ажиллаж байна.<br>Салбарын инженер, техникийн ажилтны их, дээд боловсролын мэдээллийг бүрэн цахимжуулж, ХУР системээр дамжуулан мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны яам болон Архивын ерөнхий газартай хамтран ажиллаж байна. | | | |
| | | Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээнд холбогдох | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "E-Mongolia" цонхонд дараах 5 үйлчилгээ холбогдоод байна. Үүнд:<br>1.Газрын кадастрын нэгж талбарын тодорхойлолт;<br>2.Газар эзэмших эрхийн лавлагаа;<br>3.Үнэгүй газар өмчилсөн эсэх лавлагаа;<br>4.Газрын төлбөрийн тооцоо нийлсэн лавлагаа;<br>5.Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн шүүхийн шийдвэртэй эсэх лавлагаа;<br>Газрын нэгдмэл сангийн удирдлагын системээр дамжуулан 23 үйлчилгээ, 15 лавлагаа, бусад 5, нийт 42 төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлсэн.<br>Мөн Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "E-Mongolia" цонхонд дараах 5 үйлчилгээний холбоосыг оруулсан байна. Үүнд: | 100 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 1.Геодезийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авах;<br>2.Геодезийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл сунгах;<br>3.Геодезийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл сэргээх;<br>4.Геодезийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл нөхөж авах;<br>5.Геодезийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тодорхойлолт. | | | |
| 2 | 4.1.2.2. зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх | Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх<br><br>Төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх үйл ажиллагааг дэмжиж, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 18, 21, 22, 23 дугаар тушаалуудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгэх үйл ажиллагааг 3 жилийн хугацаатай сунгасан ба энэхүү арга хэмжээний хүрээнд Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг “Монгол барилгын үндэсний ассоциаци” ТББ болон түншлэгч 7 төрийн бус байгууллага, Барилгын материалын үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг “Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ гүйцэтгэж байна. Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” ТББ болон түншлэгч 12 ТББ гүйцэтгэж байна. | 100 | | |
| 3 | 4.1.2.7. төрийн үйлчилгээний чанар, | Төрийн үйлчилгээний чанар хүртээмжид | Яамны Дотоод аудитын 2021 оны ажлын төлөвлөгөөний дагуу Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох | 100 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах | хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх | зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан.<br><br>Тус тендерт шалгарсан "Монголын үндэсний дотоод аудиторуудын холбоо" ТББ-тай 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр "Эрсдэлийн үнэлгээ хийх тухай" 2021/218 тоот гэрээг байгуулан төлөвлөгөө гарган ажилласан.<br><br>Төлөвлөгөөнд заасан ажлууд хийгдэж дууссан.<br>Тус зөвлөх багаас БХБ-ын яамны 160, харьяа байгууллагын 259 нийт 419 аудитлах үйл ажиллагааны орчныг тодорхойлж гаргасан. Аудитын эрсдэлийн үнэлгээний загварыг олон улсын эрсдэлийн удирдлагын холбоо PRMIA, Дотоод аудитын олон улсын холбооноос боловсруулж гаргасан, хүлээн зөвшөөрч ашиглагддаг сургалтын болон бодит эрсдэлийн үнэлгээний загвар материалуудыг ашиглан БХБЯ, түүний харьяа байгууллагуудад зориулсан эрсдэлийн үнэлгээний загварыг 5 бүрэлдэхүүнтэй боловсруулсан. Эрсдэлийн үнэлгээг 5 үзүүлэлтээр үнэлэж дүгнэсэн. Үүнд:<br>• Санхүүгийн нөлөөлөл<br>• Зохицуулалтын нөлөөлөл<br>• Үйл ажиллагааны нөлөөлөл<br>• Төсөв, төлөвлөгөөний нөлөөлөл<br>• Эрсдэл/боломжийн тохиолдолд магадлал<br>Эрсдэлийн үнэлгээний үр дүнг эрсдэлийн ангилал, дэд ангилалаар нь авч үзвэл:<br>• Стратегийн эрсдэл 22 буюу 6 хувь<br>• Бодлогын эрсдэл 35 буюу 12 хувь<br>• Үйл ажиллагааны эрсдэл 607 буюу 82 хувь тус тус байна.<br>Ажлын үр дүнг 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Сайдын шуурхай зөвлөгөөнд танилцуулсан. | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр** | | | | | | |
| 1 | 4.1.3.2. төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл, зарцуулалтын хөндлөнгийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх | Санхүүгийн үйл ажиллагаанд аудитын байгууллагаар аудит хийлгэж, өгсөн зөвлөмжийг мөрдөж биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх | 2020 онд сайдын багцын нэгдсэн тайланд хамрагдсан яамны төв аппарат, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, төрийн өмчит, “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ, “Хот суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл” зэрэг 4 байгууллага аудитын “Зөрчилгүй”, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК “Хязгаарлалттай”, сайдын багцын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт тус тус авсан. Аудитын шалгалтаар 451.5 сая төгрөгийн албан шаардлага, 154.6 сая төгрөгийн зөвлөмж, зөрчил илэрсэн.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалт, тусгай зориулалтын шилжүүлэг, норм нормативын сан, Дэд бүтэц ашиглалтын өмнөх захиргаа, “Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ төсөл”, Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл санхүүгийн тайлан сайдын багцын түүвэрт хамрагдан аудитын шалгалт хийгдсэн.<br>Сайдын 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 1/2031 дугаартай албан бичгээр Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлалууд”-ын дагуу Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх аймаг, нийслэлээс ирүүлсэн 1.7 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 270 төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн, үнэлгээ хийсэн жагсаалтыг | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сангийн яаманд хүргүүлсэнээс гадна улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим программаар хугацаанд нь илгээсэн.<br>Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 1/3248 дугаартай албан бичгээр Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлалууд"-ын дагуу БХБ-ын сайдын багцын 2022 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөллийг нэгтгэн, боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэнээс гадна улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим программд холбогдох мэдээлэл болон шаардлагатай баримт, материалуудыг хугацаанд нь оруулан илгээсэн.<br>Мөн БХБ-ын сайдын 2022 оны төсвийн төслийн талаарх мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулан ажилласан.<br>Сайдын багцын санхүүгийн нэгдсэн тайлан, харъяа байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд Үндэсний аудитын газраас гаргасан аудитын зөвлөмж, акт албан шаардлагын хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан ажиллаж байна. | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | 4.1.3.4. төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах | Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn, www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх | Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 1/2031 дугаартай албан бичгээр Монгол Улсын Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлалууд"-ын дагуу Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 1.7 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 270 төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн, үнэлгээ хийсэн жагсаалтыг Сангийн яаманд хүргүүлсэнээс гадна хөрөнгө оруулалтын цахим программаар хугацаанд нь илгээсэн. Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 1/2031 дугаартай албан бичгээр Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлалууд"-ын дагуу Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх аймаг, нийслэлээс ирүүлсэн 1.7 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 270 төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн, үнэлгээ хийсэн жагсаалтыг Сангийн яаманд хүргүүлсэнээс гадна улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим программаар хугацаанд нь илгээсэн.<br>Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 1/3248 дугаартай албан бичгээр Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлалууд"-ын дагуу БХБ-ын сайдын багцын | 100 | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2022 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөллийг нэгтгэн, боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэнээс гадна улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим программд холбогдох мэдээлэл болон шаардлагатай баримт, материалуудыг хугацаанд нь оруулан илгээсэн.<br>Мөн БХБ-ын сайдын 2022 оны төсвийн төслийн талаарх мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулан ажилласан. | | | |
| 3 | 4.1.3.7. аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах | Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх | Сайдын багцын санхүүгийн нэгдсэн тайлан, харъяа байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд Үндэсний аудитын газраас гаргасан аудитын зөвлөмж, акт албан шаардлагын хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан ажиллаж байна. | 100 | | |
| **Долоо. Авлигаас урьдчилагн сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр** | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 4.1.7.1. төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах замаар авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн оролцоог дэмжих | Шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах | Яамны Дотоод аудитын 2021 оны ажлын төлөвлөгөөний дагуу Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан.<br><br>Тус тендерт шалгарсан "Монголын үндэсний дотоод аудиторуудын холбоо" ТББ-тай 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр "Эрсдэлийн үнэлгээ хийх тухай" 2021/218 тоот гэрээг байгуулан төлөвлөгөө гарган ажилласан.<br>Төлөвлөгөөнд заасан ажлууд хийгдэж дууссан.<br>Тус зөвлөх багаас БХБ-ын яамны 160, харьяа байгууллагын 259 нийт 419 аудитлах үйл ажиллагааны орчныг тодорхойлж гаргасан. Аудитын эрсдэлийн үнэлгээний загварыг олон улсын эрсдэлийн удирдлагын холбоо PRMIA, Дотоод аудитын олон улсын холбоооос боловсруулж гаргасан, хүлээн зөвшөөрч ашиглагддаг сургалтын болон бодит эрсдэлийн үнэлгээний загвар материалуудыг ашиглан БХБЯ, түүний харьяа байгууллагуудад зориулсан эрсдэлийн үнэлгээний загварыг 5 бүрэлдэхүүнтэй боловсруулсан. Эрсдэлийн үнэлгээг 5 үзүүлэлтээр үнэлж дүгнэсэн. Үүнд:<br>• Санхүүгийн нөлөөлөл<br>• Зохицуулалтын нөлөөлөл<br>• Үйл ажиллагааны нөлөөлөл<br>• Төсөв, төлөвлөгөөний нөлөөлөл<br>• Эрсдэл/боломжийн тохиолдолд магадлал<br>Эрсдэлийн үнэлгээний үр дүнг эрсдэлийн ангилал, дэд ангилалаар нь авч үзвэл:<br>• Стратегийн эрсдэл 22 буюу 6 хувь<br>• Бодлогын эрсдэл 35 буюу 12 хувь<br>• Үйл ажиллагааны эрсдэл 607 буюу 82 хувь тус тус байна. | 100 | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Ажлын үр дүнг 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Сайдын шуурхай зөвлөгөөнд танилцуулсан. | | | |
| 2 | 4.1.7.3. төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг | Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтын зарцуулалтыг ил тод нээлттэй болгож, нийтэд мэдээллэх | Барилга, хот байгуулалтын яам болон ТББ-ууд хооронд төрийн чиг үүргийг гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээний 2020 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Удирдлагын зөвлөлийн хурал, 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн Сайдын зөвлөлийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлсэн. Үүнд:<br><br>1. "Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ-тай байгуулсан гэрээ; | 100 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | бий болгох, төрийн зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх | Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа ТББ-ын үйл ажиллагаанд мониторинг хийж, дүнг олон нийтэд мэдээллэх, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авах | 2.“Монголын Барилгачдын нэгдсэн холбоо” ТББ-тай байгуулсан гэрээ;<br><br>3.“Монголын архитекторуудын эвлэл” ТББ-тай байгуулсан гэрээ;<br><br>4.“Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-тай байгуулсан гэрээ зэрэг болно.<br><br>Дээрх төрийн бус байгууллагуудтай байгуулсан 2020 оны гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж БХБ-ын сайдын зөвлөлийн хурлаар 2021 оны 04-р сард хэлэлцүүлсэн.<br>Төрийн бус байгууллагуудад төсвөөс олгож байгаа санхүүжилтийг шилэн дансанд ил тод мэдээлж хэвшсэн. | | | |
| 3 | 4.1.7.4. орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагын дэргэд авлигаас урьдчилэн сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг | Орон нутаг дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагын дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллуулах | Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/101 дүгээр тушаалаар Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар ахлуулан газар, хэлтсийн дарга, ахлах шинжээч, шинжээчдийн бүрэлдэхүүнтэй байгуулагдсан эрхэлсэн асуудал, салбарын хүрээнд хүнд суртал, авлигын индексийг бууруулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ төлөвлөж, баталсан төлөвлөгөө /2020-2024 он /-ний дагуу ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгээс харьяа агентлаг, байгууллагууд, төслийн нэгжийн удирдлагуудтай цахим уулзалтыг сар тутам зохион байгуулж, цахим уулзалтын хүрээнд хүнд суртал, авлигын индексыг бууруулах чиглэлээр үр дүнтэй ажил төлөвлөж ажиллах, албан хаагчдыг авлигын эрсдэлд өртөхөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх, мөн салбарын үйл ажиллагааг ил тод нээлттэй болгож, авлигад өртөх өндөр эрсдэлтэй үйл | 100 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах ажиллуулах | | ажиллагаа /тусгай зөвшөөрөл олгох/-ны цахим шилжилтийг үе шаттайгаар шуурхай хийх зэрэг асуудлыг хөндөж, зарим үр дүнтэй ажиллаж байгаа харьяа байгууллагуудын сайн туршлагыг судлах, түгээн дэлгэрүүлэх зэргээр туршлага солилцох, мөн түүнчлэн Засгийн газраас болон холбогдох байгууллагуудаас ирүүлсэн үүрэг, чиглэлийг баримтлан сахилга бат, хариуцлагыг чанд сахиж ажиллахыг үүрэг болгох зэргээр үр дүнтэй ажиллаж байгаа болно. Авлигатай тэмцэх хөтөлбөрийн биелэлтийг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж протоколын хамт 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03/180 тоот албан бичгээр Авлигтай тэмцэх газарт хүргүүлсэн. Яамны авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ, “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлд 03/718 тоот албан бичгээр хүргүүлж мөн яамны цахим хуудсанд байршуулсан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор яамны дотоод бүтцийн нэгжүүдэд мэдээлэл өгч ажиллаж байна. | | | |
| **Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 4.1.10.1. авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх | Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг байгууллагын нийт албан хаагчдын дунд 2 удаа зохион байгуулсан бөгөөд тус сургалтад нийт давхардсан тоогоор 128 албан хаагч хамрагдсан. | 100 | | |
| 2 | 4.1.10.4. авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах | Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх | Коронавируст цар тахлын үеийн гамшгийн нөхцөл байдалтай холбоотойгоор сургагч багш бэлтгэх сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулахаар тодорхой ажил төлөвлөж ажиллаж байна. | 100 | | |

**Хоёр. Авлигатай тэмцэх, авлига, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар бусад хууль тогтоомжид заасныг хэрэгжүүлэх хүрээнд:**

| № | Агуулга /холбогдох хууль тогтоомжийн заалт/ | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжилт | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллагын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Улсын Их Хурраал хэлэлцэгдэх хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо нөхцөлөөр хангах<br><br>Авлигын эсрэг хуулийн /5.1.1./ | Яамны цахим хуудсанд хууль тогтоомжийн төсөл, түүний үзэл баримтлал, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийсэн тайланг байршуулж, ирүүлсэн саналыг хэрхэн хүлээж авсан талаарх мэдээллийг байршуулж хэвшинэ. | Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж шинэ Засгийн газар бүрэлдсэнтэй холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 1/1234 тоот албан бичгээр хуулийн төслийг холбогдох материалын хамт Монгол Улсын Шадар сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад болон Засгийн газрын гишүүдэд тус тус хүргүүлж, санал авах ажлыг зохион байгуулсан.<br>Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 3/1572, 3/1573 тоот албан бичгээр Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах албан тушаалтны мэдээллийг холбогдох 5 яам, 6 агентлаг, 2 төрийн бус байгууллагуудаас авч, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 06 дугаар сарын 02-ны 127 дугаар тушаалаар Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан.<br>Мөн Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулах тухай тушаалын төслийг боловсруулж, тус Ажлын хэсэгт орж ажиллах албан тушаалны нэр, холбогдох мэдээллийг ирүүлэх тухай 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 3/1759 тоот албан бичгийг холбогдох 16 байгууллагад хүргүүлж, 12 | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгууллагаас тус Ажлын хэсэгт орох албан тушаалтны мэдээллийг ирүүлээд байна. Барилга, хот байгуулалтын яамны цахим хаягийн /https://mcud.gov.mn/forum/ хэлэлцүүлэг хэсэгт Газрын багц хуулийн төсөл, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай анхдагч хуулийн төсөл, Барилга, байгууламжийн төвөгшлийн ангилалыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрмийн төсөл, Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн төсөл, Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийн төсөл, Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх журмын төсөл, Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төслийн төгсгөлийн тайлан, Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журмын төсөл, Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загварын төсөл, Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журмын төсөл, Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай --орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журмын төсөл, Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг хуулийн этгээдэд олгох, түүнд хяналт тавих журмын төсөл, Барилга байгууламжийн цахим тооцооллын программ Хангамжийг баталгаажуулж, хэрэглэх журмын төсөл, Барилгын түр шатны стандартын /MNS…:2021/ төслүүдэд санал авахаар 2021 онд байршуулсан. | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |
| 2 | ХАСХУМ, ХАСХОМ, мэдэгдэл тайлбарыг хуульд заасны дагуу гаргуулан хяналт тавих, тайлагнах<br><br>/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан | ХАСХУМ, ХАСХОМ, мэдэгдэл, тайлбарыг хуульд заасны дагуу тавих, гаргуулан хяналт тавих, тайлагнах | Яамны хэмжээнд нийт 62 албан хаагчаас 2020 оны ХАСХОМ-ыг цахимаар хүлээн авч тайланг АТГ-т хүргүүлсэн.<br>2021 оны жилийн эцсийн байдлаар шинээр томилогдсон 32 албан хаагчийн ХАСХОМ-ыг хугацаанд нь авч хянан баталгаажуулав.<br><br>Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т "Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол түүнийг тухай бүр 30 хоногийн дотор мэдүүлнэ" гэж заасны дагуу тайлант хугацаанд их хэмжээний өөрчлөлтийн талаарх мэдүүлгийг хүлээж аваагүй байна. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлэх тухай хууль/ | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | Авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилга а явуулах, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх | БХБЯ болон тухайн салбарын чиг үүргийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан болон хууль тогтоомжид заасаар эрх шилжүүлэн авсан, эрхийг төлөөлөн хэрэгжүүлдэг байгууллагуудтай хамтран авлигын эсрэг болон сонирхлын зөрчлийн эсрэг хууль тогтоомжийг сурталчлах арга хэмжээ зохион байгуулах | Авлигатай тэмцэх хөтөлбөрийн биелэлтийг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж протоколын хамт 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03/180 тоот албан бичгээр Авлигтай тэмцэх газарт хүргүүлсэн.<br>Яамны авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ, “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлд 03/718 тоот албан бичгээр хүргүүлж мөн яамны цахим хуудсанд байршуулсан.<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор яамны дотоод бүтцийн нэгжүүдэд сургалт мэдээлэл өгч ажиллаж байна. | 100 | | |
| 4 | Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол оруулж хэвших /Шилэн дансны тухай хуулийн 6, 7 дугаар зүйл/ | Цахим системд мэдээлэл оруулах албан хаагчдыг тодорхойлж, үйл ажиллагааг ньтогтмолжуулж, хяналтыг сайжруулах | Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын дагуу календарчилсан төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээллийн тайланг улирал бүр гаргуулан авч Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.2 дахь хэсэгт заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын багцын 2020 оны 4 дүгээр улирлын тайланг 2021.01.22-ны өдрийн 10/325 тоот, 2021 оны 1 дүгээр улирлын тайланг 2021.04.20-ны өдрийн 05/1434 тоот албан бичгээр Сангийн яамны Төсвийн хяналт эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлсэн. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх | 16.6. АТГ-ын даргын 2018 оны А/123 дугаар тушаалаар баталсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлж ажиллах | “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ын 1-д нийтийн албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэсэн сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг нийтэд өөрийн зардлаар хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар заасан бөгөөд тайлант хугацаанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн үндэслэлээр албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгээгүй байна. | 100 | | | |

Танилцсан:

Төрийн нарийн бичгийн дарга С.МАГНАЙСҮРЭН

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.БАЯРСАЙХАН